

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт тус бүрээр хяналтад авч, гүйцэтгэлийн хүрсэн тувшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 зорилго, 3 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилтийн явц 70.0 хувиар үнэлэгдэв. Эдгээр зорилт, арга хэмжээнүүд нь 2021 онд “тодорхой үр дунд хүрсэн” буюу 70 хувийн хэрэгжилттэй байна.

**Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн
үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл**

№	Арга хэмжээ	Тайлбар	Үнэлгээ (хувь)
	Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой ёсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.		
	Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:		
1.	Арга хэмжээ 4.2.1. хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлнэ.		70.0
2.	Арга хэмжээ 4.2.11. эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн	тодорхой үр дунд хүрсэн	70

	байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.		
Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:			
3.	Арга хэмжээ 4.6.1. хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бурдуулж, хөгжүүлсэн байна.	тодорхой үр дүнд хүрсэн	70
Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохицой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.			
Зорилт 6.2. Байгаль орчны хамгаалах, нөөцийг зохицой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно:			
4.	Арга хэмжээ 6.2.4. хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ.	тодорхой үр дүнд хүрсэн	70
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын үнэлгээний дүн		70.0	

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.8. дахь заалтад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичиг байна гэж заасан. Үүний дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулж хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.
- “Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химиийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ” арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан төсөл, хөтөлбөрүүдийг хамруулж тайлагнасан.
- Зорилт, арга хэмжээний суурь болон зорилтот түвшинг “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д заасны дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2. дахь заалтын аргачлалын дагуу тооцсон болно.
- “Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд

нөхөн сэргээлт хийнэ” арга хэмжээний хүрсэн түвшин тодорхойгүй байна. Учир нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.2 дахь заалтын дагуу уулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж тайлагнадаг.

5. Зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээнүүдийг үр дүнтэй болгох зорилгоор холбогдох газрууд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд үнэлгээ өгч, санал, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7.1.а.-д урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нөөцөд суурилан боловсруулсан, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусгасан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх тухайн таван жилд хэрэгжүүлэх эрэмбэ дараалал бүхий арга хэмжээ байх гэж заасан. Үүний дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах,
2. Холбогдох нэгжүүд зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг тайлагнахдаа тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг товч бөгөөд тодорхой бичиж, зорилтот түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгааныг бичиж хэвших,
3. Холбогдох нэгжүүд биелэлт гаргахдаа Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5-д заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр тайлагнаж хэвших.

Хянасан:
ХШУДАГ-ЫН дарга



Ч.Одхүү

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан;
ХШУДАГ-ЫН мэргэжилтэн  Ж.Энхсайхан

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

№	Зорилго, зорилт, арга хэмжээ	Төсөв (сая төгрөг)		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Хүрсэн түвшин буоу гүйцэтгэ- лийн хувь	Хүрээгүй шалтгаан нөхцөлийн тайлбар					
		төсөвлөсөн	гүйцэтгэл		он	түвшин	он	түвшин								
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээх хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.																
Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:																
1.	Арга хэмжээ 4.2.1. хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.	-	-		2020	-	2021	-	УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д "хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үзэлэх аргачлал", Үндсан хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой болон бусад судалгааны тайлан, Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг эцэслэн боловсруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг ашигт малтмалыг хайгуулын шатнаас уурхайн хаалт хүртэлх үе шатанд нээлттэй, хяналттай байх бодлогыг шингэсэн, байгаль орчин, орон нутаг болон иргэдийн оролцоог тодорхой зааж, хариуцлагатай, нээлттэй, үр өгөөжтэй, тогтвортой байх өөрийн болон гадаад оруудын сайн туршлагад суурилсан, салбарын шинэчлэлийн бодлогын суурь бичиг баримтын хүрээнд боловсруулсан. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 10.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (32.4%) их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.9 (34.5%) их наяд төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 649.6 (34.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нэлэөлсөн байна. Тухайлбал, катодын зэс, нүүрсэн шахмал тулш, металл бэлдэц болон баяжуулсан нүүрсний үйлдвэрлэл өссөн байна.	70						

2.	<p>Арга хэмжээ 4.2.11. эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн худэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрсхимиийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох темер зам, ус, эрчим хүчиний төслийдийг хэрэгжүүлнэ.</p>			<p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх төслийн гүйцэтгэлийн хувь</p>	369,317.30	322,939.30	2020	-	2021	-	<p>2021.12.30-ны өдрийн байдлаар “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажлын явц 75%-д, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 90%-д, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 82.5%-д, засварын механикийн заводын өргөтгөл шинэчлэлийн ажил 30%-д хүрсэн.</p> <p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийх ажлын гүйцэтгэл 69.4%-тай байна.</p>	70	
				<p>Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төслийн гүйцэтгэлийн хувь</p>	772,590.50	316,731.0	2020	-	2021	-	<p>ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хэлэлцэж хүлээн авсан. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Гүний усны ордоос Тавантолгой уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан Өмнөговь аймгийн Засаг дарга захирамж гаргасан. Тус усан хангамжийн системийг цахилгаанаар хангах техникийн нөхцөлийг ЭХЯ болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХХ-аар гаргуулсан. Ус хангамжийн системийн зураг төсөл боловсруулах ажил дууссан. Баталгаажуулах гарын үсэг зурах, экспертизээр хянуулах шатанд хүлээгдэж байна. Зураг төсөл, холбогдох шийдвэр гаргах ажлууд 95%-тай. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв /салбар темер зам, ачих байгууламж/-барилга байгууламжийг барьж байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулж, барих тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлуулсан. Засгийн газрын 2021.04.28-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай 113 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолд Тавантолгойн ордод түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэрийн</p>	70	

бүтээн байгуулалтын ажлыг ТЭЗҮ-ийн дагуу 2021 оны III улиралд багтаан эхлүүлж, 2023 онд ашиглалтад оруулахыг УУХҮСайд болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТҮЗ-д даалгасан. Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 956,447,866,100 төгрөгийн өртөг бүхий тендерийг 2021.11.15-ны өдөр дахин зарласан бөгөөд 2021.12.15-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.

Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурvas газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Энэ хүрээнд Гашуунсухайт боомтод 30 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, 2021.09.20-ны өдөр Улсын комиссад хүлээлгэн өгч, улмаар 2021.10.03-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой” ХК-иуд бүтээн байгуулалт, санхүүжилтийн гэрээг байгуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Тавантолгой” ХК-д тус бүр дотооддоо терминалыг ашиглах албыг байгуулсан. Шивээхүрэн боомтод 11.6 га талбайд чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Монголын алт (МАК)” ХХК, “Саусгоби сэндс” ХХК, “Хүрэн толгой коал майнинг” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Жавхлант орд” ХХК, “Цагаан өвөлжөө” ХХК, “Сан транс” ХХК-иуд гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 65%-тай байна. Цаашид дээр дурдсан 8 аж ахуйн нэгж хамтарсан компани байгуулахаар төлөвлөж байна. Засгийн газрын 2020 оны 254 дүгээр тогтоолын дагуу хилийн Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн 4 гаалийн хяналтын нэмэлт гарцыг “Монголын Алт” (МАК) ХХК барьж, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Одоогоор хилийн Шивээхүрэн боомтод нэмж 2 гаалийн хяналтын нэмэлт гарц барих ажил хийгдэж байна. Мөн хил хүртэлх авто замыг өргөтгөх ажил хийгдэж байна.

			Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн гүйцэтгэлийн хувь	2020	-	2021	-	Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын ерөнхий гүйцэтгэгч Жэй Эм Си Прожектс лимитед компани 2020.01.15-ны өдөр үйлдвэрийн талбайн ажлыг эхлүүлсэн. EPC-1 багц ажлын зураг төслийн ажил 90%, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2021.12.07-ны өдрийн байдлаар 42,0%-тай байна. Мөн Бор хөөврийн.govios ус дамжуулах шугам хоолойн ажлууд болох өргөх станцын барилга-31,4%, 11 ширхэг худгийн барилга-31,3%, ус нөөцлөх савны барилга-65,1%, ЦДАШ-22,1%, ус дамжуулах хоолой-17,2%, үйлдвэрийн хашаан доторх авто зам-22,6%, зам талбайн ус зайлцуулах хоолой-12,4%, зам талбайн ус хураах талбай-81,6%, замын доорх ус дамжуулах хоолой-82,4, технологийн шугам хоолойн сувагчлал-61,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.12.30-ны өдөр хүлээн авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.05.20-нд зарласан бөгөөд цар тахлын нөхцөл байдал, ажлын цар хүрээ, тендерт оролцогч компаниудын хүснэгтийг харгалзан тендер хүлээн авах хугацааг 2022.01.28-ны өдөр хүртэл сунгаад байна. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын тухайд лиценз зээмшигчдээс ирүүлсэн тендерийн техникийн хэсгийг хянах, үнэлэх ажил хийгдэж байна.	70	
369,317.30	3,350.00	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн гүйцэтгэлийн хувь	2020	-	2021	-	Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтооолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химиийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын 2 дахь хэсэгт зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. БНХАУ-ын China ENFI Engineering Co., Ltd (ENFI) болон China nonferrous metal industry's foreign engineering and construction Co., Ltd (NFC) консорциум нь “Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор боловсруулах металлурги-химиийн үйлдвэр	50	Ковид-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан БНХАУ-д хөл хорио тогтоосноос гэрээт ажлын явц удааширч, гүйцэтгэгч компанийас гэрээний хугацааг сунгах мэдэгдэл ирүүлсэн.	

									байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Төслийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд China ENFI Engineering компанитай 2021.05.10-ны өдөр зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн /металлургийн/ хийнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилт гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Туршилтын үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар боловсруулагдсан ТЭЗҮ-д тодотгол хийнэ. China ENFI компани туршилтын үйлдвэр барьж байгуулах ажлын явцын талаар 2021.12.31-ний өдөр сүүлийн тайланг ирүүлсэн. Тайланд дурдсанаар зураг төслийн ажил 85%-ийн гүйцэтгэлтэй, тоног төхөөрөмжийн худалдан авалт 75%-тай байна..		
	38,475.0	38,475.0	Алтанширээт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн гүйцэтгэлийн хувь	2020	-	2021	-	"Болд төмөр Ерөө гол" ХХК өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт "Хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төсөл"-ийг 2019-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж, төсөл хэрэгжүүлэх газар (140 га)-ыг бүрэн шийдвэрлэж, 12 км төмөр зам, 6.3 МВт-ын цахилгааны дэд станц, 110 кВ, 10 кВ-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугамууд барьж байгуулан төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг 2021 онд ашиглалтад оруулсан. Бор хөөвөр, Долоодын.govиос гүний ус дамжуулах 103 км урттай шугамын трассын зураглал хийлгэсэн ба ТЭЗҮ боловсруулах ажлын явц 70% гүйцэтгэлтэй байна. Мөн нүүрс угаах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн ба газар ширеэ, суурин ажил 90%-тай, 2022 онд ашиглалтад оруулна.	90		
Зорилт 4.2. үнэлгээний хувь										70	
Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:										70	
3.	Арга хэмжээ 4.6.1. хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн	-	-	-	2020	-	2021	-	Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сан байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн холбогдох судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Уг судалгааны үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан	70	

дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна.							гарагаар Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авч хуулийн төсөлд саналыг тусгасан. Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Улс уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2021.12.10-ны өдрийн 01/306 дугаар албан бичиг хүргүүлээд байна.		
---	--	--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4.6. үнэлгээний дүн

70

Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно:

4.	Арга хэмжээ 6.2.4. хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл эжиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ.	-	-	2020	-	2021	<p>Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг Ялбаг, Бугант тосгонд 2021.04.09-12-ны өдрүүдэд уул уурхайн болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайд эвдэрсэн газрын тооллого хийх зорилтыг хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоолын 3, 2019 оны 355 дугаар тогтоолын 1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтыг зохион байгуулахад "Ялбаг" гэх газарт экскаватор 20, ковш 7, ачааны машин 4, алт угаах төхөөрөмж 12, "Харганат" гэх газарт экскаватор 9, ковш 6, алт угаах төхөөрөмж 2, "Өлөнт" гэх газарт экскаватор 7, ковш 3, "Хорийн даваа" гэх газарт экскаватор 10, алт угаах төхөөрөмж 2 нийт 82 техник хэрэгслийг ууланд нуусан болон нутгийн иргэдийн гадна байрлуулсан байсныг бүртгэлжүүлж 5 хэсэг газарт нэгтгэн байрлуулж, 77 техник хэрэгслийн эзэмшигчийг тогтоож, тус аймаг дахь Цагдаагийн газрын дарга, сумын удирдлагад уулнаас татан буулгах, дахин хууль бусаар ашигт малтмал олборлуулахгүй байх ажил арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл өгсөн.</p> <p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүд 2021 онд 202 аж ахуйн нэгжийн 1,782 га талбай, 2917.9 сая төгрөгийг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.2 дахь заалтын дагуу уулын ажлын жилийн тайлланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргадаг. Зарим ашигт малтмалын тусгай</p>	70	
----	--	---	---	------	---	------	--	----	--

								зөвшөөрөл эзэмшигчдийн төлөвлөгөөнд орон нутгийн Байгаль орчны газраас дүйцүүлэх нөхөн сэргээлт хийх талбайг зааж өгөөгүйн улмаас зөвхөн зардлын хэмжээ тавигдсан байгаа тул тус тоо ашиглалтын үйл ажиллагааны тайлангийн мэдээлэл өөрчлөгдөх магадлалтай юм.		
								70		
								70.0		

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хяналтад авч, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, зорилтот түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар 3 шалгуур үзүүлэлт тусгагдсан ба тэдгээрийн гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг доорх хүснэгтэд харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (хувь)
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	83.3
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.0
3.	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	57.1

“Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь” шалгуур үзүүлэлтийн хувьд Евро-5 стандартын шатахууны импортын үнэ, ердийн шатахууны үнийн зэрүүгээс шалтгаалан зорилтот түвшинд хүрээгүй гэсэн бол уул уурхай болон боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөд Коронавируст халдвар (COVID-19) сөргөөр нөлөөлсөн.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Уул уурхай, хунд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д туссан суурь түвшинг, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д туссан 2021 оны хүрэх түвшинтэй харьцуулан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1. дэх заалтын аргачлалын дагуу тооцсон болно.
2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д “Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь” шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь харгалзах он буюу 2015 оны импорт, хэрэглээний хэмжээ, нийт шатахуунд эзлэх хувь гэж тодорхой туссан байна. Харин “Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн суурь түвшин хэдэн он болох нь тодорхойгүй, “Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д туссан 2021 оны хүрэх түвшингээс их үзүүлэлттэй байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд учир дутагдалтай байлаа.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7.1.а.-д урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нөөцөд суурилан боловсруулсан, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусгасан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх тухайн таван жилд хэрэгжүүлэх эрэмбэ дараалал бүхий арга хэмжээ байх гэж заасан. Үүний дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах,
2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох аргачлал, хугацаа, мэдээллийн эх сурвалжийг тодорхой болгох,

3. “Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг хэрхэн тодорхойлсныг тогтоох, цаашид хэрхэн тайлагнах, хүрэх түвшинг ямар аргачлалаар тооцох зэрэг асуудлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж шийдвэрлэх шаардлагатай байна.

Хянасан:
ХШУДАГ-ЫН дарга



Ц.Одхүү

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан;
ХШУДАГ-ЫН мэргэжилтэн *Ж.Энхсайхан* Ж.Энхсайхан

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

№	Шалгур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Тайлант хугацаанд хүрсэн түвшин	Мэдээлэл цуглуулах арга зүй, эх үүсвэр	Зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан нөхцлийн тайлбар	Үнэлгээ /хувь/
			ОН	түвшин	ОН	түвшин				
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	-	24.3	2021	25.5	25.3 Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 18%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 68-70%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73%, нийт экспортын 94%, Улсын төсвийн 26%-ийг тус тус бүрдүүлж байна. Уул уурхайн салбарын орлого зэсийн баяжмал, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг голлох ашигт малтмалаас төвлөрч байна. Дээрх дөрвөн голлох нэр төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 95%-ийг бүрдүүлж байна.	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт; Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт; Статистикийн мэдээллийн нэгдсэн сан		83.3
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	-	10.9	2021	9.7	2021 оны III улирлын байдлаар боловсруулах үйлдвэрийн ДНБ (оны үнээр)-д эзлэх хувь 6.8% байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6.9%-иар өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр, 8,681.9 тн катодын зэс, 33,082.2 тн металл бэлдэц, 33,041.1 тн металл цувимал, 3,744.4 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт; Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт; Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 10.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (32.4%) их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.9 (34.5%) их наяд төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 649.6 (34.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.	30.0

3.	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	хувь	-	8	2021	15	<p>байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад катодын зэс 114.1 тн буюу 1.3 хувь, металл бэлдэц 17,801.0 тн буюу 2.2 дахин, металл цувимал 16,387.9 тн буюу 98.4 хувиар тус тус ёссөн байна. Харин ган тэмэр хийц 1,116.9 тн буюу 23.0 хувиар, цахилгаан утас 20.25 тонн буюу 27 хувиар буурсан байна.</p> <p>12 Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2021.12.10-ны өдрийн байдлаар нийт 1.6 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 1.4 сая тонн шатахуун импортолсон байна. Үүнд: дизелийн түлш 902.9 мянган тонн, автобензин 516.3 мянган тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин 37233 тонн, дизелийн түлш 120019 тонн, нийт 157252 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 11 хувийг эзэлж байна.</p>	<p>УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт;</p> <p>Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт;</p> <p>УУХҮСайдын 2018 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам</p>	<p>ОХУ-ын “Роснефть” компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны импортын үнэ ердийн шатахууны үнээс тонн тутамдаа төрлөөс хамааран 25-60 ам.доллараар өндөр байдгаас шалтгаалан Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа 60-100 төгрөгөөр өндөр байна. Энэхүү үнийн зөрүүтэй холбоотойгоор Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээ дорвитой нэмэгдэхгүй байгаа болно. Иймд үнийн зөрүүг арилгах зорилгоор автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, өөрөөр хэлбэл хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахуунд ногдох онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас тодорхой хувиар бага тогтоох эрх зүй, татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарч ирсэн. Энэ хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хуулийн теслийг боловсруулан 2021.02.04-ний өдрийн 01/291 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2021 онд ОББҮХ-той хамтран хэрэгжүүлэх арга</p>	57.1

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН 2021-2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2021 оны жилийн эцсийн байдлаар/**

2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтэнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан төслүүдийг хяналтанд авч, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтооолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэнд сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан төслийн хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт санал зөвлөмж боловсруулав.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх 11 төсөл байгаагаас уул уурхайн 6, хүнд үйлдвэрийн 3, газрын тосны 2 төсөл байна. Хөтөлбөрт тусгагдсан 11 төслийн 2021 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл 83.3 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 50.0 хувийн биелэлттэй дүгнэгдэв.

**МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГТГЭЛ
(2021 оны жилийн эцсийн байдлаар)**

Хүснэгт 1

№	Төслийн нэр	Ажлын гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
1	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах	42.0%	90	8.5%	30
2	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл.	5.0%	50	4.0%	30
3	Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл	69.4%	90	87.4%	100
